


БАТЛАВ
 СҮХБААТАР ДҮҮРГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
 ТЭРГҮҮЛЭГЧДИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА БӨГӨӨД АЖЛЫН АЛБАНЫ
 ДАРГЫН ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ  Д.АЗЖАРГАЛ

2018 оны 01-р сарын 15-ны өдөр

**СҮХБААТАР ДҮҮРГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
 АВЛИГЫН ЭСРЭГ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ 2018 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ**

№	Бодлогын зорилт	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хугацаа	Хариуцах эзэн
А	1	2	3	4
<p>Нэг. Шударга, хариуцлагатай, ил тод нийтийн албыг бэхжүүлэх замаар авлигын эрсдэлээс урьдчилан сэргийлэх, төрийн жинхэнэ албан хаагчийн сонгон шалгаруулалт болон томилгоонд улс төрийн нөлөөллөөс ангид, мэдлэг, боловсролд суурилсан мерит зарчмыг хэрэгжүүлэх зорилтыг хангах чиглэлээр</p>				
1	Төрийн албаны төв байгууллагын дүгнэлт, хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг хянасан байдлыг үндэслэн албан тушаалд томилох тухай хуулийн хэрэгжилтийг хангах, хариуцлагыг дээшлүүлэх	<ul style="list-style-type: none"> - Шинээр ажилтан сонгон шалгаруулах ажлын ил тод нээлттэй байдлыг хангах /Сул орон тооны зар болон сонгон шалгаруулалт явуулах журам, сонгон шалгаруулалт явуулсан талаарх дэлгэрэнгүй мэдээллийг цахим хуудас, мэдээллийн самбарт байршуулж байх/ - Сул орон тоог нөхөхөд хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг Авлигатай тэмцэх газраар хянуулж дүгнэлт гаргуулах 	Жилдээ	Захиргааны хэлтэс
2	Нийтийн албанд томилогдох албан тушаалтны ёс зүй, мэдлэг, боловсрол, туршлага, ур чадварын шалгуурыг олон улсын жишигт нийцүүлэн шинэчлэх, албан тушаалтныг мэдлэг, боловсролд суурилсан мерит зарчмыг баримтлан томилох, дэвшүүлэх	<ul style="list-style-type: none"> - Төрийн албан хаагчдын ажил үүргийн хуваарь, ажлын байрны тодорхойлолтыг цахим хуудсанд байршуулах - Байгууллагын хүний нөөцийн жагсаалт, төрийн албанаас түр чөлөөлөгдсөн албаны тухай хуульд заасан үндэслэлээр чөлөөлөгдсөн төрийн албан хаагчийн нөөцийн бүртгэлийг ил тод, нээлттэй болгох 	Жилдээ	Захиргааны хэлтэс
3	Нийтийн албан тушаалтанд холбогдох авлига, ашиг сонирхол, ёс зүйтэй холбоотой гомдол, мэдээллийг хүлээн авах, хянан шалгах, хариуцлага хүлээлгэх арга хэлбэрийг тодорхой болгож, дотоод хяналтын тогтолцоог бүрдүүлэх	<ul style="list-style-type: none"> - Албан тушаалтанд холбогдох авлига, ашиг сонирхол, ёс зүйтэй холбоотой өргөдөл, гомдол, мэдээллийг хүлээн авах, хянан шалгах - Өргөдөл, гомдол, санал, хүсэлт, мэдээллийг хүлээн авах нөхцлийг бүрдүүлэх /утас, хайрцаг/, санал хүсэлтийн дэвтэр, факс, цахим, бичгээр, амаар гэх мэт - Улирал болгон иргэдийн өргөдөл, гомдол, санал, хүсэлтийг шийдвэрлэсэн талаар цахим хуудсаар мэдээлэх 	Тухай бүр	Зохион байгуулалтын хэлтэс

4	Төрийн байгууллага хоорондын хамтын ажиллагааг хөгжүүлж, мэдээлэл солилцох нөхцөл, боломжийг сайжруулах	<ul style="list-style-type: none"> - Албан хэрэг хөтлөлтийн "Edoc" нэгдсэн системээр бусад төрийн захиргааны байгууллагатай мэдээлэл солилцох, албан хэрэг хөтлөлтийн шийдвэрлэлтийн үйл ажиллагаанд хяналт тавих 	Жилдээ	Захиргааны хэлтэс
5	Нийтийн албаны сургалтын институт байгуулах, албан тушаалтныг давтан сургах боломжийг бүрдүүлэх	<ul style="list-style-type: none"> - Авлигын эсрэг хууль болон Захиргааны ерөнхий хууль, Нийтийн албан тушаалд нийтийн болон хувийн ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Зөрчлийн тухай хуулиудыг хэрэгжүүлэх талаар албан хаагчид, иргэдэд сурталчлах - Авлигын эсрэг сургалт зохион байгуулах 	Жилдээ	Захиргааны хэлтэс, Иргэний оролцооны хэлтэс
Хоёр. Төсөв, санхүү, аудитын үйл ажиллагааны удирдлага, хяналтыг сайжруулах, ил тод байдлыг хангах, төсвийн хөрөнгө, гадаадын зээл, тусламжийг үр ашигтай, зориулалтын дагуу зарцуулах, хариуцлагыг дээшлүүлэх зорилтыг хангах чиглэлээр				
6	Улсын болон орон нутгийн төсөв, санхүүгийн удирдлагын тогтолцоог сайжруулах, ил тод, нээлттэй, хариуцлагатай байх зарчмыг мөрдүүлэх	<ul style="list-style-type: none"> - Шилэн дансны тухай хуулийн дагуу төсөв, санхүүгийн үйл ажиллагаатай холбоотой мэдээллийг хуулийн хугацаанд мэдээлэх /цахим хуудсанд байршуулах/ - Тухайн жилийн төсөв /1-р сарын 10-ны дотор/, өмнөх оны төсвийн гүйцэтгэл /4 дүгээр сарын 1-ний дотор/, дараа жилийн төсвийн төсөл /8 дугаар сарын 15-ны дотор/ цахим хуудсанд байршуулах - Санхүүгийн үйл ажиллагааны хагас жилийн болон жилийн эцсийн санхүүгийн тайланг цахим хуудас болон мэдээллийн самбарт хуулийн хугацаанд байршуулах - Тухайн жилийн төсөвт орсон өөрчлөлтийн талаарх мэдээллийг цахим хуудас болон мэдээллийн самбарт байршуулах - Цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэрийн хамт гүйлгээ хийснээс хойш 7 хоногийн дотор байршуулах - 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр хаягийг тухай бүр цахим хуудсанд байршуулах 	Хуульд заасан хугацаанд	Захиргааны хэлтэс
7	Төсвийн төсөл хэлэлцэхэд олон нийтийн оролцоог хангах	<ul style="list-style-type: none"> - Орон нутгийн хөгжлийн сангаар хийгдэх төсвийн төслийн талаар хэлэлцүүлэг өрнүүлэх, төсвийн төсөлд олон нийтийн саналыг авч тусгах 	2,3 дугаар улиралд	Захиргааны хэлтэс, Иргэний оролцооны хэлтэс
8	Аудитын дүгнэлтийн дагуу авах арга хэмжээ, хариуцлагын тогтолцоог сайжруулах	<ul style="list-style-type: none"> - Санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлтийг бүрэн эхээр нь цахим хуудас болон мэдээллийн самбарт хуулийн хугацаанд байршуулах /4 дүгээр сарын 25-ны дотор/ - Аудитын дүгнэлт, зөвлөмжийн дагуу авч хэрэгжүүлсэн арга хэмжээг цахим хуудсанд байршуулах /7 дугаар 01-ний дотор/ 	Хуульд заасан хугацаанд	Захиргааны хэлтэс
Гурав. Шүүх эрх мэдлийн болон хууль сахиулах байгууллагын шударга, ил тод, хараат бус байдлыг бэхжүүлэх, авлигын эсрэг хамтын ажиллагааг сайжруулах зорилтыг хангах чиглэлээр				

9	Хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө, орлогын мэдүүлгийн маягтыг боловсронгуй болгож, мэдүүлгийг цахим хэлбэрээр хүлээн авах тогтолцоонд бүрэн шилжүүлэх	<ul style="list-style-type: none"> - Албан тушаалтнуудад ХАСХОМ гаргах талаар хуулийн хугацаанаас өмнө мэдээлэл өгөх, ХАСХОМ-ийг заавар журмын дагуу хугацаанд нь гаргуулж авах, тайланг АТГ-т хүргүүлэх - Албан тушаалтны хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө орлогын мэдүүлэг, мэдэгдэл, тайлбарыг бүртгэх, хянах, хадгалах ажлыг хуулийн дагуу зохион байгуулах - Эрх бүхий албан тушаалтнууд болон ХАСХОМ мэдүүлэгчдийг чадавхижуулах, сургалт зохион байгуулах, холбогдох гарын авлага, материалаар хангах ажлыг зохион байгуулах 	Хуульд заасан хугацаанд	Захиргааны хэлтэс
Дөрөв. Шударга ёсны үзэл санааг төлөвшүүлэн, олон нийтийг соён гэгээрүүлэх үйл ажиллагааг үе шаттай зохион байгуулж, авлигын эсрэг боловсролыг дээшлүүлэх зорилтыг хангах чиглэлээр				
10	Авлигын эсрэг хууль тогтоомжийг сурталчлах үйл ажиллагааг зохион байгуулах чиглэлээр аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэний танхим болон Эрх зүйн туслалцаа үзүүлэх төвтэй хамтран ажиллах	<ul style="list-style-type: none"> - Авлигын эсрэг хууль, тогтоомжийг иргэдэд сурталчлах - Боловсруулж байгаа бодлогын баримт бичиг болон нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ тогтоосон шийдвэрийг цахим хуудсандаа тогтмол байршуулах - Дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргаас 2018 онд хэлэлцүүлж, гаргахаар шийдвэрлэсэн бодлогын баримт бичигт олон нийтийн саналыг тусгахаар хэлэлцүүлэг, уулзалтыг иргэд, олон нийтийн оролцоотойгоор зохион байгуулж, бодлого шийдвэрт тусган хэрэгжүүлэх - Авлигын эсрэг хуульд заасны дагуу байгууллага, албан тушаалтан албан үүргээ гүйцэтгэж байх явцдаа олж мэдсэн, авлигатай холбоотой асуудлыг шалгаж байх явцдаа олж мэдсэн авлигатай холбоотой асуудлыг шалгаж шийдвэрлэх нь өөрийн бүрэн эрхэд хамаарахгүй байвал АТГ-т мэдээлэх 	Жилдээ	Захиргааны хэлтэс, Иргэний оролцооны хэлтэс
11	Төрийн байгууллагуудын авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийн үр дүнг сайжруулах	<ul style="list-style-type: none"> - Авлигын эсрэг үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх - Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулж батлуулах - Авлигын эсрэг үйл ажиллагааны хэрэгжилтийг зохион байгуулж тайлагнах 	1 дүгээр улирал Жилдээ	

ХЯНАСАН: ЗАХИРГААНЫ ХЭЛТСИЙН ДАРГА

БОЛОВСРУУЛСАН: ЗАХИРГААНЫ ХЭЛТСИЙН АЖИЛТАН



Б.ЭРДЭНЭХУЯГ



Ч.ЭНХЖАРГАЛ